

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай
хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай анхдагч хуулийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Үүнээс хойш банкны засаглалыг сайжруулах, хараат бус, бие даасан байдлыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх зорилгоор 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр тус хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Энэ хуулийн хүрээнд өнгөрсөн жилүүдэд тус банкиг тойрсон үйл явдал, хэрэг, зөрчлийг хянан шалгах, банкны зарим удирдлага, албан тушаалтнууд болон иргэд, хуулийн этгээдтэй холбогдсон гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой асуудлыг хууль, шүүхийн байгууллагын зүгээс Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу хянан шалган шийдвэрлэх, хууль тогтоомж, эрх зүйн орчинд нь тодорхой өөрчлөлт, шинэчлэл хийх, Засгийн газрын зүгээс удирдлага, зохион байгуулалтад нь анхаарч, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэг тодорхой арга хэмжээ авч ирсэн байна.

Тус банкны санхүүгийн нөхцөл байдал хүнд байсан ч олон улсын зах зээлээс татан төвлөрүүлсэн, 2022-2023 онуудад буцаан төлөх хуваарьтай зарим бондын эргэн төлөлтийн эх үүсвэрийг төвлөрүүлэхийг зорилго болгож, банкны бүхий л үйл ажиллагааг зээл төлүүлэхэд чиглүүлсэн байх бөгөөд энэ ажлын хүрээнд 1.7 их наяд төгрөгийн зээл, хүүгийн төлбөрийг төлүүлж, Засгийн газрын баталгаатай 30 тэрбум иений Самуурай бонд, бие даан татан төвлөрүүлсэн 500 сая ам.долларын Евро бондыг болон бусад хуваарьт эх үүсвэрийн төлбөрийн хамт нийт 3.1 их наяд төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулжээ.

Гэсэн хэдий ч банкны актив хөрөнгө 2017 онд 5.8 их наяд төгрөг байсантай харьцуулахад 60 хувь буурч 2024 оны жилийн эцсийн байдлаар 2.4 их наяд төгрөг болсон бөгөөд банк шинээр зээл олгох, төсөл санхүүжүүлэх, эх үүсвэр татах үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлээгүй, удаан хугацаанд зогсонги байдалд байснаас үйл ажиллагааны хүрээ хумигдаж, цаашид хуулиар зөвшөөрсөн үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахад эрх зүйн шинэчлэл хийж, институтийн чадамжийг сайжруулах зайлшгүй шаардлага бий болсон байна.

Нөгөө талаас Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан этгээдийг хариуцлагатай байлгах, Хөгжлийн банк санхүүжилт олгох шалгуур, шаардлага, судалгаа, шинжилгээ, төслийн хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалт дутмаг байсаар ирсэн. Хөгжлийн банкны зээлдэгч зээлийн санхүүжилтийг зориулалт бусаар ашигласан, зарцуулалт баримтаар нотлогдохгүй, төсөл хэрэгжээгүй тохиолдлууд олон байгаа нь зарим тохиолдолд талууд анхнаасаа төслийг хэрэгжүүлэх санаа зорилгогүй байсныг илтгэж байгаа бөгөөд төслийн хэрэгжилтэд тавих хяналт сул, хариуцлагын тогтолцоо сул байсныг харуулж байна. Хуулийн хийдэл, зохицуулалтын дутмаг байдал нь авлига, хахуулийг өөгшүүлж, судалгаа шинжилгээ, тооцоололд суурилсан мэргэжлийн шийдвэр гаргалт бус харин хувийн ашиг сонирхол, улс төрийн нөлөөлөлд автсан

шийдвэр гаргалтын шалтгаан болж иржээ.

Хөгжлийн банкны зээлийн багцын 57.5 хувь буюу 1.3 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь чанаргүй ангилалд шилжсэн, цаашлаад тус банкны гадаад улсаас татан төвлөрүүлсэн бондын эргэн төлөлт хангагдахгүйд хүрч, дефолт зарлах эрсдэл үүссэн хэвээр байгаа нь эрх зүйн хэм хэмжээ сул байсаар байгаагийн үр дагавар гэж үзэж болохоор байна.

Иймээс дээр дурдсан алдааг эрх зүйн харилцааных нь орчинд дахин гаргахгүй байх, Хөгжлийн банкны үйл ажиллагааг сэргээх, эрх зүйн орчныг сайжруулж, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагын үүднээс Монгол Улсын Хөгжлийн банкны хуулийг шинэчлэн найруулах замаар зарчмын хэд хэдэн өөрчлөлт оруулж, хөгжлийн болон төслийн санхүүжилт, экспорт, импортын санхүүжилттэй холбоотой харилцаа, ажил үйлчилгээг өргөтгөн зохицуулж, Хөгжлийн банкиг экспортыг дэмжигч банк байхаар хуулийн төслийг боловсрууллаа.

Төслийг боловсруулахдаа олон улсын Хөгжлийн банкнуудын алдаа ба сайн туршлагыг судалж, харьцангуй амжилттай хөгжиж байгаа Зүүн Азийн орнуудын Хөгжлийн банкнуудын үйл ажиллагаатай өөрийн банкны нөхцөл байдлыг жишиж, дүгнэсэн болно.

Тухайлбал, Япон улсын Засгийн газар дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд Хөгжлийн банкнаас нь санал өгч, уг хөтөлбөрт нийцтэй байдлаар өөрсдөө сонгон судалж, төслүүдийг санхүүжүүлж ажилладаг. Хууль, эрх зүйн орчин нь тус банкиг улсын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх гол институт гэж тодорхойлон банкны үйл ажиллагааны хүрээ, зорилго, зорилт, сайн засаглалын элементүүд, хараат бус төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавих шаардлага, бие даасан шийдвэр гаргалтыг дэмжсэн удирдлагын зөв тогтолцоог бий болгосон байна. Банк нь үйл ажиллагаандаа мөрдөх санхүүгийн харьцааны үзүүлэлтүүдийг тогтоож, тогтмол хангаж ажилладаг, санхүүжүүлж буй төсөл нь эдийн засгийн үр ашигтай байх, хяналтын шат дараалсан цогц тогтолцоог бий болгосон учраас Япон улсын Хөгжлийн банк улсынхаа хөгжлийг дэмжин амжилттай ажиллаж чадаж байна.

Түүнчлэн Хөгжлийн банкны захирлыг хэн томилдог талаарх судалгаагаар банкнуудын 54% нь харьяа яамны сайд эсвэл тухай Улсын ерөнхийлөгч байсан бол 34% нь төлөөлөн удирдах зөвлөл сонгодог байна. Байгууллага бүрд гүйцэтгэх захирал сонгоход өөр өөр шалгуур тавьдаг байна. Зарим нь нарийн, тодорхой шалгууруудтай бол зарим нь маш тодорхой бус шалгуур тавьсан нь улс төрийн шийдвэр гаргах боломжийг олгодог байна. Нийт хөгжлийн банкнуудын 63% нь боловсрол болон ур чадварын шалгуур, 43% нь банк болон санхүүгийн байгууллагад ажилласан туршлага, 65% нь дампуурал зарласан компанид бүртгэлгүй байх, 70% нь ашиг сонирхлын зөрчилгүй байх зэрэг шаардлагуудыг тавьдаг байна. Банкнуудын 61%-д гүйцэтгэх захирал тодорхой хугацаанд томилогддог бол үүний 53%-д уг хугацаа нь 3-6 жил байсан байна.

Энэхүү хуулийн төслийг боловсруулахдаа дээр дурдсан сайн жишиг, өнгөрсөн сургамжаасаа санаа авч, Хөгжлийн банкны эрх зүйн байдал, чиг үүргийг шинээр тодорхойлж, тогтвортой хөгжлийг хангах экспортыг дэмжсэн зорилтот зах зээлийг

бодлогоор санхүүжүүлэхээр эрхлэх үйл ажиллагааны чиглэл, эрх хэмжээг шинээр тодорхойлж, засаглал, хяналт, хариуцлагын тогтолцоогоо сайжруулах өөрчлөлтүүдийг төсөлд тусгасан болно.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 10 бүлэг, 46 зүйлээс бүрдэх бөгөөд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагад үндэслэн дараах агуулгаар шинэчлэн найруулна:

1.Хуулийн Нэгдүгээр бүлэгт хуульд хэрэглэгдэх санхүүгийн ажил, үйлчилгээний талаарх ойлголтыг энэ хуульд хэрэглэх нэр томъёоны 4 дүгээр зүйлээр нэмж тодорхойлов.

Хуулийн нэр томъёо нь тодорхой, нэг мөр ойлголттой байх нь хууль тогтоомжийг зөв хэрэгжүүлэхэд чухал ба нэр томъёоны зөв хэрэглээ нь хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал үүрэгтэй. Иймд хууль зүйн маргаан, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 4 дүгээр зүйлээр нэмж оруулна.

Хөгжлийн банк нь төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төслийн онцлогт тохируулан санхүүжилтийн төрөлжсөн арга хэрэгсэл ашиглах шаардлагатай ба төслийн санхүүжилт, экспортын санхүүжилт, ногоон санхүүжилт, худалдааны санхүүжилт зэргийг хуулиар тодорхойлж, тавигдах шаардлагуудыг мөн ялгамжтай тодорхойлох нь тохиромжтой.

Тухайлбал, нийтээр ойлгож хэвшсэн “зээл”, “барьцаа”-ны ойлголтоос төслийн санхүүжилтийн механизм өөр тул “төслийн санхүүжилт/project finance”-ийг хуульд тодорхой болгон хуульчилна. Мөн одоогийн хуулийн 8.1.9-т “*Экспорт, импортын санхүүжилт хийх*” үйл ажиллагааг эрхэлнэ гэж заасан. Мөн тус хуулийн 17.1-д “*Экспорт, импортын санхүүжилт хийх төсөл, хөтөлбөр нь 10.1 дэх шаардлагыг хангасан байх*”-аар тусгагдсан нь банк энэ хуулийн хүрээнд гадаад худалдааны санхүүжилтийн төлбөр тооцоотой холбоотой бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, өргөжүүлэх, харилцагчдад санал болгоход хүндрэл, бэрхшээл үүсэхээр байгаа юм. Учир нь гадаад худалдааны санхүүжилт нь “Худалдааны гэрээ хэлцэл”-д үндэслэн олон улсын стандарт, банкнуудын нэгдсэн журмаар зохицуулагдаж явагддаг үйл ажиллагаа тул Хөгжлийн банк нь урт хугацаанд ЭКСИМ банкны үүргийг гүйцэтгэхэд гадаад худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээг авах харилцагчдад тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичгийг ойлгомжтой болгохын тулд хуульд ойлгомжтой тодорхой байдлаар тусгасан.

Одоогийн хуулийн 8.1.1.төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх;	Одоогийн хуулийн 8.1.3.баталгаа, батлан даалт гаргах;	Одоогийн хуулийн 8.1.9.экспорт, импортын санхүүжилт хийх;
<p>10.1.Хөгжлийн банк дараахь шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ:</p> <p>10.1.1.Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх;</p> <p>10.1.2.эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай, зээлийг эргэн төлөх чадвартай байх;</p> <p>10.1.3.техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн байх;</p> <p>10.1.4.эдийн засгийн өсөлт, экспортыг дэмжих, импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн байх;</p> <p>10.1.5.төслийн эрсдэлийн үнэлгээ, санхүүжилт авах үндэслэл, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр нөлөөг мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх;</p> <p>10.1.6.энэ хуулийн 8.1.7-д зааснаас бусад санхүүжилт нь Засгийн газрын өрийн баталгаа, барьцаа, баталгаа зэрэг үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгслээр хангагдсан байх.</p> <p>10.2.Хөгжлийн банк энэ хуулийн 10.1-д заасан шаардлага хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлнэ.</p> <p>10.3.Энэ хуулийн 10.1-д зааснаас бусад нөхцөл, шаардлагыг Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл тодорхойлно.</p> <p>10.4.Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх шийдвэрийг Хөгжлийн банк гаргах ба шийдвэр заргахтай холбоотой журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.</p>	<p>12.1.Хөгжлийн банк нь энэ хуулийн 25.1-д заасан үзүүлэлт, журам, 28 дугаар зүйлд заасан хязгаарлалтад нийцүүлэн дангаар болон бусад этгээдтэй хамтран гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргаж болно.</p> <p>12.2.Баталгаа, батлан даалтыг энэ хуулийн 10.1.2-10.1.5-д заасан шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрт гаргаж болно.</p>	<p>17.1.Экспорт, импортын санхүүжилт хийх төсөл, хөтөлбөр нь энэ хуулийн 10.1-д заасан шаардлагыг хангасан байна.</p>

2. Монгол Улсын Хөгжлийн банкны эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт банкны эрх зүйн статусыг “Хөгжлийн банк нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн зорилтыг дэмжих чиг үүрэг бүхий төрөөс үүсгэн байгуулсан хөгжлийн институт мөн.” гэж өөрчилж банкны үйл ажиллагаа явуулах хэлбэрийг тодорхойлов.

Хөгжлийн банк нь өнгөрсөн хугацаанд санхүүжилт шаардлагатай байгаа төсөл, хөтөлбөрүүдэд санхүүжилт олгох, нөгөө талаар хөрөнгө оруулагчидтай эдгээр төслүүдийг санхүүжүүлэх, эх үүсвэр татах замаар хамтран ажиллаж ирсэн.

Цаашид амжилттай ажиллаж буй бусад улсын хөгжлийн банкуудын жишгээр улсын хөгжлийн бодлогын дагуу зорилтот салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрт санхүүжилт олгох чиглэлээр ажиллах шаардлагатай. Хөгжлийн банкны үйл ажиллагааны чиглэл буюу олон улсын жишиг дараах байдалтай байдаг:

- Санхүүжилт шаардлагатай байгаа төсөл, хөтөлбөрүүдийн эдийн засгийн болон нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг судлах, үнэлэх;
- Хөрөнгө оруулагчидтай том төсөл санхүүжүүлэх замаар хамтран ажиллах;
- Эдийн засгийн өсөлтөд чухал шаардлагатай салбарт техникийн туслалцаа үзүүлэх;
- Санхүүгийн зах зээлд хурдасгуурын үүргийг гүйцэтгэх, хөрөнгө оруулагчдыг татах;
- Эдийн засгийн мөчлөгийн эсрэг үйл ажиллагаа явуулах буюу хямралын үед зээл олгох, дотоод, гадаадын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар санхүүгийн хямралын сөрөг нөлөөллийг бууруулах.

Түүнчлэн Монгол Улсын цорын ганц бодлогын банкны хувьд эдийн засгийн мөчлөгийг сөрсөн бодлогын шинж чанартай арга хэмжээг хэрэгжүүлэн зах зээлийг

тогтвортой байлгах, улс төрийн тогтворгүй байдал, сонгуулийн циклийг үл харгалзан томоохон төслүүдийг үргэлжлүүлэн санхүүжүүлж амжилттай дуусгах үүрэг хүлээх юм.

3.Монгол Улсын Хөгжлийн банкны зорилт, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, эрх хэмжээг 6, 7, 8 дугаар зүйлүүдэд тодорхой заасан.

Бусад орны Хөгжлийн банкнуудын хууль эрх зүйн орчин цаг үетэйгээ нийцэн өөрчлөгдөж ирсэн байна. Тухайлбал, Солонгосын хөгжлийн банк байгуулагдсан цагаас эхлэн улсын эдийн засгийн нөхцөл байдал, Засгийн газрын бодлоготойгоо уялдуулан Солонгосын Хөгжлийн банкны тухай хууль болон холбогдох баримт бичгүүддээ тухай бүр өөрчлөлт оруулж үйл ажиллагаандаа мөрддөг байна (Солонгосын хөгжлийн банк 1995 оноос хойш нийт 10 удаа буюу 1995, 1997, 1998, 1999, 2002, 2008, 2009, 2010, 2016, 2020 онуудад хуулиа шинэчилсэн).

Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хууль анх батлагдсанаас хойш 2017 онд нэг удаа шинэчилсэн бөгөөд түүнээс хойш улсын эдийн засгийн нөхцөл байдал, Засгийн газрын бодлого болоод бусад хуультай нийцүүлэн хуулийг шинэчлээгүй.

Хөгжлийн банкны үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилго бүхий хууль эрх зүйн орчны шинэчлэлт хийхийн тулд нэн тэргүүнд Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн найруулах, улмаар МУХБ-ны дүрэм, болон бусад бодлогын баримт бичгүүдийг засаглал, удирдлагын олон улсын зарчмуудтай болон ижил төстэй хөгжлийн банкнуудын дотоод зохицуулалтын баримт бичгийн жишигт нийцүүлэн Хөгжлийн банканд хууль эрх зүйн хувьд үүсээд байгаа хийдлийг арилгах зайлшгүй шаардлага үүссэн тул холбогдох өөрчлөлтийг тусгасан.

2011 онд батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар банкны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг УИХ жил бүрийн хаврын чуулганаар баталдаг байхаар зохицуулсан. Харин 2017 онд батлагдсан, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд заасны дагуу хуулийн шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрт бие даан санхүүжилт олгодог болсон. Энэ нь УИХ, Засгийн газраас хамааралгүйгээр Хөгжлийн банк мэргэжлийн байгууллагын хувьд бие даан шийдвэр гаргаж, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг тус банкны эрх бүхий албан тушаалтан хүлээдэг механизмыг бүрдүүлэх зорилготой байсан. Гэвч энэхүү өөрчлөлтийн дагуу Хөгжлийн банк хөгжлийн томоохон төслүүд гэхээсээ илүүтэй арилжааны банкны санхүүжүүлэх боломжтой, хөгжлийн бус төслүүдэд санхүүжилт олгож эхэлсэн. Тодруулбал, уг шинэчлэл нь шийдвэр гаргалтад улс төрийн нөлөөг бууруулах зорилготой байсан ч бодит байдал дээр санхүүжилт олгох шийдвэрт улс төрийн нөлөөг бууруулж чадсан гэж дүгнэх боломжгүйг өнөөдрийн үүсээд буй нөхцөл байдал харуулна.

4.Монгол Улсын Хөгжлийн банкны зарчим, хориглох үйл ажиллагаа, Хөгжлийн банканд тавигдах шаардлагыг 11, 12, 13 дугаар зүйлүүдэд шинээр зохицуулсан.

Хөгжлийн банкны үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг хуулиар тодорхойлох нь ил тод байдал, хариуцлага, ёс зүйг хангуулахад чиглэж байгаа болно.

Хөгжлийн банкнууд нь эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогын хэрэгсэл болж байдгаараа онцлогтой. Тэр утгаараа арилжааны банкнаас ялгаатай буюу үйл

ажиллагааны үр дүнд мөнгөн ашгаас илүү нийгэм, эдийн засгийн ашгийг чухалчилж үздэг тул Хөгжлийн банканд тавигдах шаардлага нь онцлог ялгаатай байх шаардлагатай.


Төсөл санхүүжүүлэх шийдвэр гаргахтай холбоотой зохицуулалтыг ойлгомжтой болгох зорилгоор тодруулсан. Гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргалтад хөндлөнгийн нөлөөлөл оруулахгүй байх, нөлөөлөхийг оролдсон этгээдэд хариуцлага тооцдог байхаар хуулийн төсөлд тусгасан. Үүний хүрээнд Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хориглох үйлдлийг тодорхой тусгасан зүйлийг нэмсэн.

5.Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн ажил үйлчилгээг банкны зорилго, зорилттой нийцүүлэн хуулийн гуравдугаар бүлэгт буюу 14-23 дугаар зүйлүүдэд шинэчлэн тодорхойлсон.


Хөгжлийн банк нь арилжааны банкнаас ялгаатай ба дараах санхүүгийн ажил, үйлчилгээ үзүүлнэ:

- зээл авах, эх үүсвэр татан төвлөрүүлэх;
- төслийн санхүүжилт;
- төлбөр тооцоо гүйцэтгэх;
- баталгаа, батлан даалт гаргах;
- үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
- валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
- компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх;
- төслийн зөвлөх үйлчилгээ;
- экспортын болон худалдааны санхүүжилт олгох;
- экспортын зээлийн баталгаа гаргах, даатгал хийх;
- ногоон санхүүжилт олгох

Тухайлбал, төслийн санхүүжилтийг уламжлалт шууд санхүүжилт эсвэл компанийн ердийн зээлийн санхүүжилтээс ялган авч үзэх ёстой. Уламжлалт шууд санхүүжилтийн хувьд зээлдүүлэгч зээлийн эргэн төлөлтийг хангахуйц мөнгөн урсгал бий болгох боломжтой тухайн компанийн бүх хөрөнгийг авч үздэг. Төслийн санхүүжилтийн ялгарах гол онцлог нь төсөл өөрөө бие даасан хуулийн этгээд болдог ба төслийн хөрөнгө, төсөлтэй холбоотой гэрээ хэлэлцээр болон төслийн мөнгөн хөрөнгийн урсгал нь төсөл санаачлагч этгээдээс бие даасан тусдаа байдагт оршино. Мөн санхүүжилтийн бүтцийн хувьд уламжлалт санхүүжилттэй харьцуулахад санхүүгийн өгөөж болон эрсдэлийг илүү үр ашигтай, зөв хуваарилдаг тул төслийн санхүүжилтийг 16 дугаар бүлэгт заасан.



- Төсөл хэрэгжүүлэгчид шууд зээлдэгчдээс санхүүжилт авдаг
- Төсөл хэрэгжүүлэгч уг санхүүжилтийг төслийг санхүүжүүлэхэд ашигладаг
- Төсөл хэрэгжүүлэгч зээлийн эрсдэлийг хариуцна



- Төсөл хэрэгжүүлэгчид зээлдэгчдээс санхүүжилт авахад зориулан Тусгай зорилдлын компани байгуулдаг
- Төслийг хэрэгжүүлэхэд болон үр дүнд бий болох хөрөнгө нь санхүүжилтийн баталгаа болдог
- Төсөл хэрэгжүүлэгч зээлийн эрсдэлийг шууд хариуцахгүй

Мөн 24, 25 дугаар зүйлүүдэд тогтвортой, ногоон бодлогыг дэмжсэн ногоон санхүүжилт олгох болон экспортыг дэмжих зорилгоор экспортын санхүүжилт, экспортын зээлийн баталгаа гаргах, даатгал хийхтэй холбоотой ажил үйлчилгээг нэмж тусгав.

Монгол Улсын хувьд Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрч, хүлээсэн үүргээ биелүүлэхэд их хэмжээний, ногоон санхүүжилт шаардлагатай. Олон улсад ногоон эдийн засаг, тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг янз бүрээр тодорхойлж байгаа ба хөгжлийн банкнуудын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээ ч энэ чиглэлээр хөгжиж байна. Гол зарчим нь хүрээлэн буй орчноо хамгаалах, нийгмийн хүртээмжтэй байдал, эдийн засгийн чадамжийг сайжруулж, хүлэмжийн хийг бууруулах болон нөөцийн үр ашигтай хуваарилалт зэргийг харгалзаж байгаа ба НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд дээр суурилдаг. Улс орнуудын нөхцөл байдлаас шалтгаалаад тэргүүлэх чиглэлүүд нь ялгаатай байх боломжтой.

Хөгжлийн банк нь Монгол Улсын хөгжлийг дэмжих бодлогын банк болохын хувьд тогтвортой хөгжлийн энэхүү хандлагын хүрээнд олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татаж тогтвортой, ногоон төсөл, хөтөлбөрт санхүүжилт олгох боломжтой юм.

Хөгжлийн банк нь ЭКСИМ банкны үүргийг хэрэгжүүлэх буюу дотоодын үйлдвэрлэгч, экспортлогчдыг дэмжихийн тулд гадаадын экспортын зээлийн агентлагуудын санал болгодог санхүүжилттэй өрсөлдөхүйц санхүүжилтийн хэрэгслүүдийг санал болгох шаардлагатай. Ихэнх улсын эксим банкнууд зөвхөн дотоодын экспортлогчдод зээл болон зээлийн баталгаа олгохоос гадна гадаадын болон дотоодын худалдан авагчдад шаардлагатай зээлийг олгодог. Экспортыг хэрхэн дэмжих талаар судалгаануудад дурдсанаар зөвхөн экспортлогчдод зээл олгох бус үйлдвэрлэгч, худалдан авагч аль алийг шаардлагатай санхүүжилтээр хангах нь илүү үр дүнтэй байдгийг харуулсан байдаг. Түүнчлэн эксим банк бусад санхүүгийн байгууллагууд болох арилжааны банк, даатгалын байгууллагуудтай өрсөлдөхгүй, харин хамтран ажилладаг. Ингэснээр санхүүжилтийн зарим хэсгийг бусад санхүүгийн байгууллагаар хангуулах, улс төрийн болон арилжааны эрсдэлүүдийг хувааж үүрэх

давуу талуудыг бий болгодог байна. Улс орон бүрийн эксим банк нь зээлдэгчийн шалгуурыг тогтоохдоо төслийн амжилттай болох магадлал, төлбөр төлөлтийн чадвар, экспортын гүйцэтгэл зэрэг уламжлалт шалгууруудад үндэслэн тогтоодог тул тус санхүүжилтэд тавих шаардлагыг банк санхүүжилтийн бодлогын баримт бичигтээ тусгасан байхаар заасан.

6.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд засаглалын тогтвортой байдал, шийдвэр гаргалтын эрх хэмжээг зөв хуваарилах, үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгөх зорилгоор Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийг томилох чөлөөлөх асуудлыг 26 дугаар зүйл, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шалгуурыг 27 дугаар зүйл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг 30 дугаар зүйлүүдэд шинэчлэн найруулж, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар 29 дүгээр зүйлийг нэмсэн.

Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсанаас хойш ТУЗ-ийн даргаар нийт 11 хүн буюу дунджаар 1.6 жил ажиллаж байна. Ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 51 өдөр, их нь 1404 өдөр буюу ажиллажээ. Ажиллаж байсан 10 хүний 5 нь дунджаар 230 хоног, 3 нь дунджаар 650 хоног, 2 нь 1000-аас дээш хоног ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүнээр нийт 30 орчим хүн ажиллаж байснаас ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 110, их нь 1404 өдөр ажилласан ба дунджаар 673 хоног ажилласан байна. Нийт 25 гишүүний 24 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 76 хувь нь 1-3.8 жил хүртэл хугацаагаар тус тус ажиллажээ.

ТУЗ-ийн хараат бус гишүүдээр нийт 20 гаруй хүн ажилласнаас ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 73, их нь 2069 өдөр ажилласан ба 16 хүн дунджаар 791 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 16 хүний 12.5 хувь нь 1 жил хүртэл хугацаанд ажилласан бол үлдсэн 87.5 хувь нь 1-ээс 5.6 жил хүртэл ажилласан байна.

Гүйцэтгэх захирлаар нийт 8 хүн томилогдсоноос хугацааны хувьд хамгийн бага нь 217, их нь 1106 өдөр ажилласан ба дунджаар тус албан тушаалд 667 хоног ажилласан байна.

Тэргүүн дэд болон дэд /орлогч/ захирал, газрын захирлаар нийт 30 гаруй хүн ажилласнаас тайлант хугацаанд 7 хүн томилогдсон өдрөөс хойш ажиллаж байна. Тодруулбал, 2013 оноос хойш эхлэн ажиллаж байгаа 2 хүн байгаа ба хамгийн богино ажилласан хүн 1 жил ба түүнээс урт хугацаанд ажиллаж байна. Нийт 3 ажилласан хугацааны хувьд хамгийн бага нь 23, их нь 3948 өдөр ажилласан ба 28 хүн дунджаар тус албан тушаалд 837 хоног ажилласан байна. Ажиллаж байсан 28 хүний 14% нь 1 жил ба түүнээс бага хугацаанд ажилласан бол 86% нь 1.2 жилээс 10.8 жил хүртэл буюу харьцангуй тогтвортой ажилласан байна.

Судалгааны дүнгээр банкны үйл ажиллагааны үр дүнг голчлон хариуцах удирдлага болон удирдлагын багийн гишүүн нэг бүрийн ажилласан хугацаа тогтвортой бус, банкны үндсэн бүтээгдэхүүн болох томоохон төслийн хэрэгжилтийн үр дүнтэй холбон авч үзвэл ажиллах хугацааны гэрээний хэрэгжилт, ажлын үр дүнг тооцох тогтолцоо хангалтгүй үйлчилж ирсэн, нөгөө талаас хараат бус байдалд нөлөөлөхүйц байсан талаар Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-

ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах Түр хорооноос хийсэн “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдал”-ыг шалгасан шалгалтын тайланд дурджээ¹.

Хөгжлийн банкнуудыг бүрэн эрхийнх нь хүрээнд ерөнхий байдлаар авч үзвэл, төрийн өндөр албан тушаалтан болон сонгогдсон улс төрчид банкны чиглэл, үйл ажиллагаанд нөлөөлөх орон зай ихтэй байдаг. Хөгжлийн банкны засаглалын бүтэц нь улс төрийн нөлөө, оролцоог тэсвэрлэх, түүнээс хамгаалах хэмжээний бат бөх биш тохиолдолд хөндлөнгийн нөлөөллөөр хэт өндөр зээлийн эрсдэл болон ирээдүйн санхүүгийн алдагдал хүлээх зэрэг сул талтай байдаг гэж олон улсын судалгаагаар дүгнэсэн байдаг.

Тухайлбал, Хөгжлийн банкны захирлыг хэн томилдог талаарх судалгаагаар банкнуудын 54% нь харьяа яамны сайд эсвэл тухай Улсын ерөнхийлөгч байсан бол 34% нь төлөөлөн удирдах зөвлөл сонгодог байна. Байгууллага бүрд гүйцэтгэх захирал сонгоход өөр өөр шалгуур тавьдаг байна. Зарим нь нарийн, тодорхой шалгууруудтай бол зарим нь маш тодорхой бус шалгуур тавьсан нь улс төрийн шийдвэр гаргах боломжийг олгодог байна. Нийт хөгжлийн банкнуудын 63% нь боловсрол болон ур чадварын шалгуур, 43% нь банк болон санхүүгийн байгууллагад ажилласан туршлага, 65% нь дампуурал зарласан компанид бүртгэлгүй байх, 70% нь ашиг сонирхлын зөрчилгүй байх зэрэг шаардлагуудыг тавьдаг байна. Банкнуудын 61%-д гүйцэтгэх захирал тодорхой хугацаанд томилогддог бол үүний 53%-д уг хугацаа нь 3-6 жил байсан байна.

Банкны засаглал, удирдлагын тогтолцоог эрх зүйн хувьд сайжруулах зайлшгүй нөхцөл үүссэн, хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг болон шийдвэр гаргалтын хүрээ, хязгаарыг эрсдэлд суурилсан оновчтой байдлаар нарийвчлан тогтоох шаардлагатай. Тухайлбал, ТУЗ-ийн хувьд одоогийн байдлаар төсөл санхүүжүүлэх шийдвэр гаргаж байгаа нь засаглалын хувьд Хөгжлийн банкны эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэхтэй зөрчилдөж байгаа тул аливаа төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх шийдвэрийг Гүйцэтгэх удирдлагын түвшинд гарган, ТУЗ нь банкны эрсдэлийн удирдлага болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны хяналтын тогтолцоог цогц байдлаар удирдан зохион байгуулах шаардлагатай.

Хөгжлийн банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий стратегийн том төслүүдийг санхүүжүүлэх бодлогын банкны статусыг хадгалахын тулд Банкны засаглал, хяналтын тогтолцоонд томоохон өөрчлөлт хийх нь зайлшгүй бөгөөд тус банкны хувьд одоо тулгараад асуудалд дүгнэлт хийхэд дараах асуудлуудад онцгой анхаарах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Үйл ажиллагааны орчин: Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны бие даасан хараат бус байдлыг хангах, бизнесийн болон

¹ Хянан шалгах Түр хорооноос хийсэн “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдал”-ыг шалгасан шалгалтын тайлан., 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр дараах хаягт нийтлэгдсэн.

<https://www.parliament.mn/files/c02d669c1686437a83235768cd005000/?d=1>

арилжааны зарчмаар үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах, эрх зүйн орчныг бий болгох.

- Удирдлага, менежмент: Хувьцаа эзэмшигч нь Банкны ТУЗ-ийн гишүүдийг төрийн удирдлага, бизнес, эдийн засгийн чиглэлээр дадлага туршлагатай, мэргэшсэн, чадавхтай хүний нөөцөөр бүрдүүлэх.
- Улс төрийн нөлөөлөл: Банкны засаглал, удирдлагын тогтолцоо нь Компанийн засаглалын сайн зарчмуудад суурилсан Засаглалын бодлоготой байх нь улс төрийн сонгуулийн циклээс хамааралтай байх болон ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг томилсон улс төрийн нам, улс төрчдийн нөлөөллөөс ангид, бие даасан бодлого хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.
- Эрсдэлийн удирдлага: Олон улсын сайн засаглалын зарчмуудад заасны дагуу комплайнс, эрсдэлийн удирдлагын тогтолцоог банкны ТУЗ нь Эрсдэлийн хороогоор дамжуулан удирдлагаар ханган ажиллах үүргийг хүлээх тул ТУЗ нь энэ асуудлыг анхааралдаа аван, цаашид энэ үүргийг онцгойлон хэрэгжүүлж ажиллах.
- Дотоод аудит: Банкны дотоод хяналтын тогтолцоо болон эрсдэлийн хамгаалалтын 3 дугаар бүсэд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж болохын хувьд дотоод аудит нь компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, аудиттай холбоотой зарчмуудыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж, Банкийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байх.

Иймд Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, Гүйцэтгэх удирдлага нь батлагдсан төлөвлөгөө, хууль, дүрэм, журмын дагуу ажиллаж буй эсэх, хувийн ашиг сонирхлоос ангид байгаа эсэхэд хяналт тавих буюу бодлогын чиглэл өгч, хяналтын чиг үүрэгтэй ажиллах өөрчлөлтийг тусгасан.

Хөгжлийн банк байгуулагдсанаас хойших хугацаанд Банкны эрсдэлийн удирдлага, Авлигын эсрэг засаглал, менежментийн дутагдалтай байдлын улмаас алдаа дутагдал гарч авлига, албан тушаалын хэргүүд үйлдэгдсэн нь тус банк төдийгүй Монгол Улсын нэр хүндэд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлсэн. Иймд авлигын тохиолдол гаргахаас сэргийлэхүйц засаглал, менежментийн тогтолцоог бий болгох агуулгатай заалт нэмсэн.

7. Гүйцэтгэх захирлын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэх захирлыг томилох, сонгон чөлөөлөх асуудлыг 31 дүгээр зүйлд, гүйцэтгэх захиралд тавигдах шалгуурыг 32 дугаар зүйлээр, гүйцэтгэх захирлын эрх, үүргийг 33 дугаар зүйлүүдэд тус шинэчлэн найруулсан.

Хөгжлийн банк үйл ажиллагаа явуулж эхэлсэн өнгөрсөн 13 жилийн хугацаанд нийт 8 гүйцэтгэх захирал, 11 төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ажиллаж, банкны дүрэм 4 удаа шинэчлэн батлагдаж, банкны бүтэц, зохион байгуулалт нийт 10 удаа өөрчлөгдсөн нь засаглал, үйл ажиллагаа, хүний нөөцийн тогтворгүй, залгамж халаагүй байдлыг бий болгосон. Иймд Хөгжлийн банкны гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахын тулд Гүйцэтгэх захирлыг Засгийн газраас томилж чөлөөлдөг байхаар тусган гүйцэтгэх захирал нь өөрийн багийн гишүүдийг өөрөө сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх эрхтэй байх нь зүйтэй байна.

Иймд тус заалтуудад Гүйцэтгэх захирлыг Засгийн газраас томилох, Гүйцэтгэх захирал нь өөрийн багийн гишүүдээ сонгон шалгаруулж, томилох бүрэн эрхийг зохицуулсан өөрчлөлт оруулсан.

8.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх, Засгийн газрын бүрэн эрх, Монголбанкны хяналтыг ойлгомжтой болгох зорилгоор тавдугаар бүлэгт Хөгжлийн банкнаас бусадтай харилцах зарчмыг ойлгомжтой болгож өөрчлөв.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 28.1.1-д “Зээл, баталгаа, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгийг 30 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй бөгөөд түүний хэмжээг Монголбанк тогтооно” гэж заасан. Энэ нь Банкны дүрмийн сан 1 их наяд төгрөг байгаатай харьцуулахад Банкнаас хамгийн ихдээ 30 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг олгох боломжтой. Дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны гүйцэтгэлээр 70 их наяд байгаагаас үзэхэд тус банкны зээл санхүүжилтийн төсөв, олгох санхүүжилтийн төлөвлөгөө нь улсын бодлого, төлөвлөлтэй уялдуулах шаардлагатай.

Засгийн газрын зүгээс цаашид стратегийн ач холбогдол бүхий, улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах хэмжээний урт хугацаанд хэрэгжих томоохон мега төслүүдийг тодорхойлж жагсаалтыг батлан, Хөгжлийн банк дангаар болон хамтран санхүүжүүлэх чиглэлийг өгдөг байх нь тохиромжтой гэж үзсэн.

9.Хөгжлийн банк чанаргүй активын эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлтэй активт бүтцийн өөрчлөлт хийх, банкны мэргэжлийн байгууллагуудын ашигладаг арга хэрэгслийг ашиглах талаар 41 дүгээр зүйлд нэмж тусгаж, арга хэмжээ авах заалт оруулав.

Өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банкны хууль эрх зүйн орчин, санхүүгийн байдлаа сайжруулах тал дээр Засгийн газрын дэмжлэгтэйгээр зарим ажлууд хийгдсэн боловч нь 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл банкны чанаргүй, хугацаа хэтэрсэн активын асуудал үргэлжилсэн хэвээр байна. Активын чанарын үзүүлэлт муудахад дараах хүчин зүйлүүд голлон нөлөөлсөн байх талтай. Үүнд:

Гадаад шалтгаан

- Хөндлөнгийн нөлөө бүхий шийдвэр гаргалт;
- Улс төрийн тогтворгүй байдал, улсын бодлогын тодорхой бус байдал (ЗГ солигдох үед залгамж халаа алдагдах, уялдаа холбоо байхгүй болох);
- Төрийн яамдаас төсөл, хөтөлбөртэй холбоотой гаргасан тогтоол шийдвэр, санхүүжилтийг шийдвэрлэхэд оролцсон оролцоо, гэрээгээр хүлээсэн үүрэгтээ хариуцлага хүлээдэггүй байдал (Төслийн захиалагч болох яамд болон харьяа дээд байгууллагын үйл ажиллагаа тогтворгүй, банктай уялдаа холбоо хамтран ажиллах саналыг төдийлөн хэрэгжүүлдэггүй);

Дотоод шалтгаан

- Банкны бодлого, удирдлага, үйл ажиллагааны тогтворгүй байдал;
- Зээлдэгчийн төсөл хэрэгжүүлэх чадамж болон санхүүгийн сахилга бат сул, хариуцлагагүй, зээлдэгч нь санхүүгийн тайлангаа үнэн зөв тайлагнадаггүйгээс шалтгаалан банкны зүгээс төслийн явцыг санхүүгийн мэдээлэлд үндэслэн хянах боломж хязгаарлагддаг;
- Зээлийг зориулалтын дагуу ашигладаггүй, банкны тавьсан шаардлагыг биелүүлдэггүй (анхны болон шинэчилсэн хуулиар банк нь хянан шалгагчтай байх талаар заасан байдаг ч бодит байдал дээр банк дотоодоос томилохоор үр дүн хангалттай хэмжээнд гараагүй);
- Төслийн хөгжүүлэлт, бэлэн байдал бүрэн хангагдаагүй, тодорхойгүй нөхцөл байдал үүссэн, төслийн ажлын гүйцэтгэгч бэлтгэн нийлүүлэгч нарт зээлдэгчийн зүгээс төслийн бүтээн байгуулалтын явцад өөрчлөлт оруулдаг;
- Төсөл хэрэгжсэн ч боловсон хүчний чадамж муугаас болж бүрэн хүчин чадлаар ажилладаггүй;
- Төсөл хэрэгжиж бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа ч импортлогч орны нөхцөл байдлаас хамааран экспортын зөвшөөрөл гарахгүй байх тохиолдолд зээлийг эргэн төлөх боломж буурдаг ба энэхүү асуудлыг холбогдох яам, агентлагийн түвшинд нэгдсэн байдлаар холбох харилцаа муу;
- Харилцагчдад үзүүлэх банкны байгууллагын иж бүрэн цогц үйлчилгээний тогтолцоо өнөөдрийг болтол бүрдээгүй (төлбөр тооцоо, зээлийн бусад бүтээгдэхүүн, санхүүгийн зөвлөгөө гэх мэт)
- Чанаргүй зээлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд банкны мэргэжлийн байгууллагуудын ашигладаг хүү бууруулах, зогсоох, чөлөөлөх, зээлийг тэнцлийн гадуур гаргах, зээлийг сангаас хэсэгчлэн хаах, зээлийг зарах, солих, барьцаа хөрөнгийг өмчлөх бусад үл хөдлөх эд хөрөнгөд бүртгэн авсан ч эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг арга хэмжээг авах зохицуулалт, эрх хэмжээ байхгүй зэрэг тодорхой шалтгаан асуудлууд байна.

Иймээс чанаргүй активын эрсдэлийг бууруулах чиглэлээр санхүүгийн байгууллагын хэрэгжүүлдэг арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг Хөгжлийн банканд хуулиар олгож, үйл ажиллагааг шуурхай явуулах нь зүйтэй гэж үзсэн.

10.Банкнаас санхүүжүүлсэн, санхүүжүүлэх төслийн үйл явц, хэрэгжилтийн байдал, санхүүжилтийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгох зохицуулалтыг 43.4 дэх хэсэгт нэмж тусгана.

Банкны ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын хариуцлагыг сайжруулахад үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал ямар чухал болохыг Хөгжлийн банкны зээлийн багцын чанарын тухай 2022 оны 1 дүгээр сард ил тод болгосон мэдээллээс харж болно. Банк цаашид Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан Компанийн сайн засаглалын зарчимд тулгуурлан үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хэрэгжүүлэх болно.

Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, түүний хэрэгжилтийн явц, судлагдаж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод байдаггүйгээс олон нийтийн хяналт дутагдаж улмаар чанаргүй активын хэмжээ жил бүр өссөөр өнөөдрийн нөхцөл байдалд хүрээд байна.

Тодруулбал, 2015-2021 онуудад Хөгжлийн банканд хийгдсэн хөндлөнгийн хяналт шалгалтуудын үр дүнд хугацаа хэтэрсэн, анхаарал хандуулах шаардлагатай чанаргүй зээлийн хэмжээ ихсэж байгаа тухай, банкны хүний нөөцийн бодлого тогтворгүй байгаа тухай, санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд тавигдах хяналт дутагдаж байгаа тухай дүгнэлт, зөвлөмжүүд удаа дараа өгч байсан боловч мэдээллийн ил тод байдал хангалтгүйгээс тухайн дүгнэлт, зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалтгүй байсаар иржээ. Иймд, Хөгжлийн банкны тухай хууль тогтоомжид банкнаас олгосон санхүүжилтийг ил тод болгох асуудлаар нэмэлт оруулах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Энэ хуулийн төсөл батлагдсанаар банкны үйл ажиллагаа сэргэж, эрхлэх үйл ажиллагаа, эрх хэмжээ, үүрэг хариуцлага, засаглалын тогтолцоо нь олон улсын стандартад нийцэх бөгөөд зээл, төслийн санхүүжилт олгохдоо илүү хариуцлагатай, мэргэжлийн судалгаа тооцоон дээр үндэслэж, санхүүжилтийн шийдвэрийг бие даасан байдлаар гаргадаг болно гэж үзэж байна.

Мөн банканд итгэх олон нийтийн болон оролцогч талуудын итгэл сэргэж, банкны нэр хүнд сайжирч, үйл ажиллагаа нь өргөжих боломж бүрдэх юм.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төв банк/Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулиудын төсөл болон 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хамт боловсруулан хүргүүлж байна.